

**“МОН-ИТ БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2018.03.15

№ 01

Улаанбаатар хот

“Компанийн тухай хууль”-ийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйлийн 60.1 дэхь хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 09:00 цагт “Мон-Ит Булигаар” ХК-ийн байранд хуралдуулсугай.
2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахи асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - 2.1 Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.
 - 2.2 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгох.
3. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан Хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал М.Мөнхбаясгалан-д үүрэг болгосугай.
5. Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдэд “Компанийн тухай хууль”-ийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэгт заасан баримт бичигтэй танилцах боломжоор ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал М.Мөнхбаясгалан-д үүрэг болгосугай.
6. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Д.Ганболд-г сонгосугай.
7. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ч.Жаргалсайхан

Гишүүд: С.Ундармаа

Ч.Тогтохбаяр

8. Хурал зохион байгуулах комиссыг дараахи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Ганболд

Гишүүд: М.Мөнхбаясгалан

Б.Болормаа

ТУЗ-ийн дарга



Д.Ганболд